

## ÄÄÐ×ÈÄ

1. Äàððàí ñòì ùí ÈÒÕ-ùí 3 äóääàð õóðàèääàí 2
2. Äàððàí ñòì ùí ÈÒÕ-ын Õýðä¿çýã-дийн хуралдаан 3
3. Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс хэрэгжүүлсэн ажлууд 4 -14
4. Иргэний танхимын хэлэлцүүлэг 15-16
5. Мэдээ, Мэдээлэл 17-19
6. Дархан сумын ГХУСА33-ийн хуралдаан 20-21
7. Дархан сумын ИТХ, Тэргүүлэгчдээс 2017 оны 2 улиралд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө 22-24

## МЭДЭЭЛЭЛ

### ÄÄÐÕÄÍ ÑÒÌ ÛÍ ÈÕÕ-ÛÍ 7 ÄÄÕÛ ÓÄÄÄÆËÍ ÑÌ Í ÄÓÓËËÍ ГУРАВДУГААР ӨӨДÄËÄÄÄÍ ÕÓДÄËËËÄ

Ääðõäí -Óë àéí æéí Ääðõäí ñòì ÛÍ ÈÕÕ-ÛÍ 7 ääõÛ óäääæëí ñì í äóóëëéí 3 дугаар õóääëäääí 2017 îí Û 3 äугааð ñäðÛí 10-í Û °ä°ð ñòì ÛÍ õóääëäääí Û òäí òèì ä ирвэл зохих 31 Төлөөлөгчөөс 26 Төлөөлөгч оролцож, 84.0 хувийн ирцтэйгээр эхлэв.

Хуралдаанд аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Б.Жаргалсайхан, ахлах мэргэжилтэн С.Батхишиг, Дархан сумын 18 багийн ИНХ-ын дарга нар оролцов.



Хуралдаанаар дараах асуудлуудыг õýéýëõýæø èéäáýðëýлээ. Үүнд:

1. Дархан сумын 2017 оны батлагдсан төсөвт тодотгол хийх тухай  
Засаг дарга Б.Азжаргал
2. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн журам”-ын хэрэгжилтийг хангуулах тухай  
Засаг даргын орлогч Д.Батбаяр
3. ИТХ-ын 2 дугаар хуралдаанаас гарсан санал, шүүмжлэлийн мөрөөр хийсэн ажлын мэдээлэл  
Сумын ЗДТГ-ын дарга О.Хүрэлчулуун
4. 2017 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлэх  
Аймгийн ГХБХБГ-ын дарга Д.Ганбаяр



## ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН

Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааныг 2017 оны 1 дүгээр улиралд 9 удаа хуралдаж, 30 гаруй асуудлыг авч хэлэлцсэн байна. Үүнд:



- ✓ “Дархан Өргөө” Политехник коллежийн 40 жилийн ойг тэмдэглэх тухай
- ✓ Сумын ГХУСАЗЗ-ийн ажиллах журмыг батлах тухай
- ✓ Дархан сумын ИТХ-ын 2017 онд хийх ажлын төлөвлөгөөг батлах тухай
- ✓ Дархан сумын Засаг даргын орлогчоор Д.Батбаярыг томилуулах саналыг хэлэлцэх тухай
- ✓ Дархан сумын багуудын ИНХ-ын анхдугаар хуралдааныг зарлах тухай
- ✓ Сонгуулийн хэсгийн дугаар, нутаг дэвсгэр, төвийг зарлах тухай
- ✓ Дархан сумын Хурлын байгууллагуудын шилдэгүүдийг тодруулах тухай
- ✓ Монголын нутгийн удирдлагын холбооны шагналд сумын ИТХ-ын Төлөөлөгч, зарим иргэдийг уламжлах тухай
- ✓ Дархан сумын ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн ээлжит 3 дугаар хуралдааны товыг зарлах тухай
- ✓ Дархан сумын ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн 3 дугаар хуралдаанаар хэлэлцэх асуудлыг батлах тухай
- ✓ Хаяг, дугаар олгох тухай
- ✓ Дархан сумын 2017 оны батлагдсан төсөвд тодотгол хийх тухай
- ✓ Монгол улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг хангуулах тухай
- ✓ Сумын ИТХ-ын хоёрдугаар хуралдаанаас гарсан санал, шүүмжлэлийн мөрөөр хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл
- ✓ Дархан сумын 2016 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах тухай
- ✓ Гэр хорооллын зарим гудамжны нэршлийг өөрчлөх тухай
- ✓ Гудамжнуудын байршил, нэр, хилийн заагийг тодотгох, нэрлэх тухай
- ✓ Дархан сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай
- ✓ “Алдарт эх”-ийн одонгоор шагнагдах эхчүүдийн материалыг хэлэлцэж аймгийн ИТХ-д уламжлах тухай
- ✓ Сонгуулийн сурталчилгааны зурагт болон ухуулах хуудас байрлуулах гудамж, талбай, олон нийтийн газрын байршлыг тогтоох тухай
- ✓ Төрийн дээд шагналд уламжлах тухай

Хуралдаан хэлэлцсэн асуудлуудаараа тогтоол гаргалаа.

## МЭДЭЭЛЭЛ

### ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИД, БАГИЙН ИНХ-ЫН ДАРГА НАРЫН ӨРГӨТГӨСӨН ЗӨВЛӨЛГӨӨН БОЛОВ

Хурлын ажлын албанаас сумын ИТХ-ын Төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга нарыг мэдээ мэдээллээр хангах, арга зүйн зөвлөгөөг өгөх зорилгоор сумын ИТХ-ын Төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга нарын хамтарсан зөвлөлгөөнийг 2 удаа зохион байгуулав.

Зөвлөлгөөнөөр Дархан сумын 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай, “Хаягжуулалтын тухай” хууль болон түүнийг дагаж мөрдөх журам, Орлого бүрдүүлэлт, Е-баримтын тухай, Засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө зэрэг асуудлуудыг хэлэлцлээ.

ГХБХБГ-аас Хаягийн мэдээллийн систем байгуулах, хаягийн зургийн төсөл боловсруулж, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулахаар ажиллаж байна.



Зөвлөлгөөний үеэр Дархан сумын зэргэлдээ сумдын хилийн зааг, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Ширээ нурууны нутаг дэвсгэрийн харъяаллын асуудал зэргийг хөндөн ярилцав.

Татварын хэлтэс хөрөнгө оруулалтын хэмжээ багассан ч орон нутгийн төсвийн орлогыг оновчтой зөв хуваарилж, төрийн үйл ажиллагаанд иргэдийн санал санаачлага, оролцоог нэмэгдүүлж, тэдний аж амьдралыг сайжруулахад туслалцаа үзүүлэх зорилт дэвшүүлсэн тухай мэдээллэв.



2017 онд иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтэд тулгуурлаж, гэр хороололд Өрхийн эмнэлэг барих, өрхийн эмнэлгүүдийн эмчилгээ, оношлогооны тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, Дархан сумын 21 дүгээр цэцэрлэгт шинээр нэг анги



## МЭДЭЭЛЭЛ

тохижуулж 36 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулахаар төлөвлөсөн байна. Мөн “Ном хөтөлбөр”-ийн хүрээнд аймгийн Төв номын санд чухал шаардлагатай 268 ширхэг номоор хангах, “Амгалан Дархан-3” төслийн хүрээнд багийн цагдаагийн хэсгийн байцаагчдын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөжээ.




Хийсэн мэдээллүүдтэй холбогдуулан зөвлөлгөөнд оролцогсад асуулт, хариулт өрнүүлж, харилцан санал солилцлоо.

### ДАРХАН СУМЫН БАГУУДЫН ИНХ-ЫН АНХДУГААР ХУРАЛДААН АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨВ

Дархан сумын 18 багийн ИНХ-ын анхдугаар хуралдаан 2017 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн Бямба гарагийн 10.00 цагт нэгэн зэрэг эхэлж, мөн өдрийн 16.00 цагт санал хураалт дуусав.

Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс баталсан журмын дагуу анхдугаар хуралдааныг зохион байгуулсан ба хууль зөрчсөн ямар нэгэн үйлдэл гараагүй байна. Багийн ИНХ-ын анхдугаар хуралдаанаар ирэх 4 жилийн хугацаанд тухайн багийг удирдан чиглүүлэх ИНХ-ын дарга, Тэргүүлэгчдийг сонгож, багийн Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн юм.



Сумын хэмжээнд 18 багийн ИНХ-ын дарга, Тэргүүлэгчид, Багийн Засаг даргад 142 иргэн нэр дэвшсэн байна. Тус сонгуульд 6941 сонгогч саналаа өгч, иргэдийн идэвхи оролцоо өндөр байв. Дунджаар нэг багт 400 орчим иргэн саналаа өгч, ИНХ-ын дарга, Тэргүүлэгчид, Багийн Засаг даргаа сонгох үйл хэрэгт идэвхтэй оролцлоо.

## МЭДЭЭЛЭЛ

Харин Дархан сумын 8 дугаар багт 751 сонгогч саналаа өгчээ. Дархан сумын багуудын ИНХ-ын анхдугаар хуралдаанаас багийн Засаг даргад нэр дэвшиж, олонхийн санал авсан буюу 50-иас дээш хувийн санал авсан Засаг дарга нарыг батламжлуулахаар сумын Засаг даргад уламжилсан байна.



### ДАРХАН СУМЫН БАГИЙН ИНХ-ЫН ДАРГА НАРЫН ЗӨВЛӨГӨӨН БОЛОВ

Дархан сумын багийн ИНХ-ын дарга нарын зөвлөгөөн 2017.02.14 ны өдөр боллоо. Зөвлөгөөнд шинээр сонгогдсон багийн ИНХ-ын дарга нарыг танилцуулж, Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн талаар ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Болдбаатар мэдээлэл хийж, Бичиг хэргийн стандартын талаар Хурлын ажилтан О.Бадамдорж зөвлөгөө өглөө. Зөвлөгөөнд УИХ-ын гишүүн Б.Баттөмөр оролцож УИХ-аас баталсан хууль тогтоомж, тойрогтоо хийгдэх бүтээн байгуулалтын ажлын талаар мэдээлэл өгч, цаашид багийн ИНХ-ын дарга нартай хамтран ажиллахаа илэрхийлэв.



Зөвлөгөөний эхэнд сумын ИТХ-ын дарга Ж.Балжинням Хурал, Засаг даргын хамтын ажиллагаа, нэгдмэл санаа, бүтээлч идэвх санаачлага, иргэддээ хандаж буй харьцаа хандлагаас нутаг дэвсгэрийн хөгжил, ард иргэдийн амьдрал ахуй шууд шалтгаална гээд хамгийн гол нь иргэд сонгогчдынхоо санаа бодол, хүсэл эрмэлзлэл дээр тулгуурлаж, нэгдмэл санаатай, нэгдсэн байдалтай, бие биедээ зарчмын өндөр шаардлага тавьж, удирдах удирдуулах ёс горимоо дагаж, нутаг дэвсгэртээ эзэн нь болж ажиллах явдал чухал болохыг онцлов.

## МЭДЭЭЛЭЛ



Авилга авах, хүнд суртал гаргах, иргэдийг чирэгдүүлэх, харилцааны соёл муу эзэмшсэнээс болж иргэдийг гомдоох явдал нь Таны ажиллаж буй орчинд бага ч гэсэн байвал, танаас хамаарахгүйгээр, таныг ямагт иргэдээс чинь холдуулаад байгаа гэдгийг санаж ажиллахыг хүслээ.

1. Дархан сумын хэмжээнд шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог сайжруулах зорилтын хүрээнд аймаг, сумын Хурлын дэргэдэх Иргэний танхимуудаас хэлэлцүүлгүүд зохион байгуулагдана. Үүнд багийн ИНХ-ын дарга нар тус бүр 5-аас доошгүй иргэний хамт оролцдог ажлыг хэвшил болгоё.
2. Багийн ИНХ ажлаа жил, улирлаар төлөвлөж хэрэгжүүлэх, биелэлтийг улирал тутамд сумын Хурлын ажлын албанд ирүүлж заншаарай.
3. Сар бүрийн эхээр багийн нийгмийн ажилтнаар дамжуулан Цагдаагийн газраас тогтмол гаргадаг бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ, саатуулах байранд саатуулагдсан иргэдийн судалгааг та бүхэнд хүргүүлнэ. Ахуйн хүрээнд архидан согтуурах явдал их байна. Зарим өдөрт 100 гаруй иргэн саатуулагдаж, тэдний тал хувь нь гэр орондоо түгшүүр төрүүлсэн байна. Ахуйн хүрээнд архидан согтуурах явдал гэмт хэргийн шалтгаан нөхцөл болж байгаа учраас энэ асуудалд та бүхэн онцгой анхаарч, хүргүүлж буй мэдээ, судалгааны мөрөөр гэмт хэрэг, зөрчилд өртсөн, эрүүлжүүлэгдсэн иргэдтэйгээ тулж ажиллахад үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллах үүрэг өглөө.



## МЭДЭЭЛЭЛ

### НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ “ТЭРГҮҮНИЙ БАЙГУУЛЛАГА”-ААР ДАРХАН СУМЫН ИТХ ШАЛГАРЛАА

Дархан хотын хөгжил цэцэглэлтэд үнэтэй хувь нэмэр оруулж, 2016 оны ажил үйлсээрээ бусдыгаа манлайлж, Дархан-Уул аймгийн хөдөлмөрийн аваргаар шалгарсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хамт олонд шагнал гардуулах ёслолын ажиллагаа 2017.02.24-ний өдөр Залуучууд театрт боллоо.



Нутгийн өөрөө удирдах ёсыг Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу төлөвшүүлэн хөгжүүлж, хуулиар олгогдсон бүрэн эрх, чиг үүрэг, сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх талаар дэвшүүлсэн зорилтоо амжилттай биелүүлж, 2016 онд хийсэн ажлаараа Дархан сумын ИТХ-ын байгууллага шалгарч, Нутгийн өөрөө удирдах ёсны “Тэргүүний байгууллага”-ын өргөмжлөл, мөнгөн шагнал хүртлээ.

### “НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ БАЙГУУЛЛАГА”-ЫН ШИЛДГҮҮД ТОДОРЛОО

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг хөгжүүлэх, иргэдийн нийтлэг эрх ашиг, орон нутгийн хөгжлийн төлөө Дархан сумын ИТХ-аас зохион байгуулсан ажлуудын үр нөлөөг дээшлүүлэхэд санаачлагатай ажилласан шилдгүүдэд шагнал гардуулав.



Сумын ИТХ-ын “Шилдэг Тэргүүлэгч”-ээр Д.Жамбалдорж, “Шилдэг Төлөөлөгч”-өөр Т.Чимгээ, мөн Б.Эрдэнэ-Очир даргатай 14 дүгээр багийн ИНХ-ыг “Тэргүүний ИНХ”-аар тус тус шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналыг сумын ИТХ-ын дарга Ж.Балжинням, ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, сумын Засаг дарга Б.Азжаргал, сумын Засаг даргын орлогч Д.Батбаяр нар гардууллаа. Мөн үеэр



## МЭДЭЭЛЭЛ



Нутгийн удирдлагын байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж нутгийн өөрийн удирдлагыг бэхжүүлж, боловсронгуй болгох, хөрөнгө санхүү, гадаад харилцааг өргөтгөхөд хүч хөдөлмөрөө зориулж үнэтэй хувь нэмэр оруулсан Ц.Бямбааг “Монголын нутгийн удирдлагын холбоо”-ны дээд шагнал “Соёмбо одон”-гоор,



Нутгийн удирдлагын холбооны “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгч Д.Туяа, Б.Бадамханд, Дархан сумын 4 дүгээр багийн ИНХ-ын Тэргүүлэгч Б.Цэдэнбал нарыг тус тус шагнаж урамшууллаа.

### ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ ХУУЛИЙН ХУГАЦААНД МЭДҮҮЛЛЭЭ.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудад заасны дагуу нийтийн албан тушаалтнууд жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор ХАСХОМ /Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг/-ээ гаргаж өгөх үүрэгтэй.



Дархан сумын ИТХ-ын ажлын албанд ХАСХОМ гаргаж өгвөл зохих сумын ИТХ-ын төлөөлөгч 31, Багийн Засаг дарга 18 нийт 46 албан тушаалтны 2016 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд meduuleg.iaас.mn цахим системд 100 хувь бүртгүүлэн баталгаажуулалтыг хийж ажилласан байна.

## МЭДЭЭЛЭЛ

### 100 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ АЗАЙ БУУРАЛД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

Дархан сумын ИТХ, ЗДТГ-аас жил бүрийн сар шинийн баяраар 100 ба түүнээс дээш настай азай буурлуудад хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай билээ. Шинийн дөрвөн буюу 2017.03.02-ны билэгт сайн өдөр Дархан сумын ИТХ-ын дарга Ж.Балжинням Дархан сумын 2,3 дугаар багийн иргэн Очирын Гээдэн, Аршийн Эрвээхэй нарт хүндэтгэл үзүүллээ.



сумын ИТХ-ын дарга Ж.Балжинням, нарийн бичгийн дарга Б.Болдбаатар багийн Засаг дарга бөгөөд тус багаас сонгогдсон Төлөөлөгч Б.Бадамханд, Д.Туяа нарын хамтаар азай буурай нарт хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулан өглөө.

### ДАРХАНЧУУДЫНХАА БУЯН ЗАЯАГ ДААТГАЖ МАНДАЛ ӨРГӨВ

Дархан-Уул аймгийн удирдлагууд Дархан хот дахь Хараагийн Дарь-Эх ламын Гэцогдаржаалин хийдэд ард түмнээ даатгаж ном хуруулж мандал өргөв. Монгол Улсын “Шинэ үндсэн хууль” батлагдаж мөрдөгдсөнөөс хойш жил бүрийн сар шинийн баяраар иргэдийнхээ заяа буян,хийморь лундааг даатган ном айлдуулж мандал өргүүлдэг уламжлал тогтжээ. Энэхүү уламжлалт, ёсын дагуу Дархан сумын ИТХ-ын дарга Ж.Балжинням, сумын ИТХ-ын Тэргүүлэгчид, ЗДТГ-ын удирдлагууд уг хийдэд мандал өргөж ирэх цагийн сайн сайхан бүхнийг аймгийнаа иргэддээ ерөөж, ирж буй “алтан унжлагат” хэмээх гал тахиа жилдээ хийх аливаа үйл хэрэг, ажил үйлсийг нь даатгав.



“Мандал өргөх ёс” нь одоо, ирээдүй гурван цагийн буянг арвитган даатгаж буй буй зан үйл юм. Хараагийн Дарь-Эх ламын Гэцогдаржаалин хийдийн Да лам



## МЭДЭЭЛЭЛ

Ж.Базаррагчаа: “Ямарваа буянт үйл үйлдсэнийхээ дараа уг буянаа Бурхан, бодьсатва нарын буянд зориулан өргөдөг ёстой. Буяны үйл нь цувирч барагддаг буян, цувирч барагддаггүй буян гэж байдаг. Бурхан, бодьсатва нарын буян нь цувирч барагддаггүй буян учраас үйлдсэн буянаа тэдэнд зориулбал барагдахгүй бөгөөд улам арвидаж байдаг гэж үздэг тул буяны үйл үйлдсэнийхээ дараа заавал зориулга, ерөөл өргөх ёстой” гэлээ.

### ДАРХАНЧУУД "ДАРХАН БЭР"-ҮҮДЭЭ ӨРГӨМЖЛӨВ

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн баярыг тохиолдуулан “Дархан бэр”-ийг алдаршуулах хүндэтгэлийн үйл ажиллагаа 2017.03.08-ны өдөр ёслол төгөлдөр боллоо. 2012 оноос хойш өнгөрсөн хугацаанд 400 гаруй ээжүүд энэхүү эрхэм хүндтэй өргөмжлөлийг хүртсэн байна. Дархан сумын ИТХ-ын дарга Ж.Балжинням, нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, ИТХ-ын Тэргүүлэгч Б.Болор-Эрдэнэ, З.Эрдэнэбат, Т.Чимгээ, Д.Жамбалдорж, ЗДТГ-ын дарга О.Хүрэлчулуун нар Залуучууд театрын их танхимд Дархан бэрийн өргөмжлөлийг хүндэтгэлтэйгээр гардуулан өглөө.



Монголчууд эрт үеэс гурван хүү төрүүлсэн бэрээ “Дархан бэр ” хэмээн өргөмжлөн хүндэлдэг.Энэ сайхан уламжлалыг дэлгэрүүлэн олон түмэндээ хүргэх “Дархан бэр”-үүдээ алдаршуулах ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааг Дархан сум 6 дахь жилдээ зохион байгууллаа. Энэ жил 68 ээж “Дархан бэр”-ээр өргөмжлөгдсөн байна.

### СУМДЫН ИТХ-ЫН УДИРДЛАГУУД БОЛОН АЖИЛТНУУДАД СУРГАЛТ ЯВУУЛАВ

Дархан-Уул аймгийн сумдын ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, хурлын ажилтнуудад аймгийн ИТХ-ын ажлын албанаас /2017.03.17/ сургалт зохион байгуулж, хууль эрх зүйн болон мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Уг сургалтаар Захиргааны Ерөнхий хууль болон Тогтоол шийдвэр гаргахад анхаарах асуудлууд, “Албан бичиг хэрэг хөтлөлт” сэдвээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Р.Тунгалаг-Эрдэнэ, “Сумдын Иргэний танхимын үйл ажиллагааг сайжруулах нь” сэдвээр аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний танхимын дарга А.Янжмаа, “Сумдын үйл ажиллагаатай танилцсан арга хэмжээний тайлан”, “2016 оны ХАСХОМ-ийн тайлан мэдээ гаргасан тухай” аймгийн ИТХ-ын



## МЭДЭЭЛЭЛ

Тэргүүлэгчдийн ажлын албаны ахлах ажилтан Н.Буманцэцэг нар тус тус мэдээлэл хийлээ.



Мөн Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд хэрэгжүүлж буй Khural.mn цахим хуудасны хэрэглээний талаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ажилтан Б.Болорцэцэг, Т.Дэлгэрсуурь нар явууллаа.

Сумдын ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, ажилтнуудад зориулсан уг сургалтын үеэр Хурлын байгууллагын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаар нээлттэй ярилцан, шийдвэрлэх арга замын тухай санал солилцлоо.

Мөн сургалтын хөтөлбөрийн дагуу Шарын гол, Орхон, Хонгор сумын удирдлагууд, ажлын албаныхан 2016 оны нутгийн өөрөө удирдах ёсны “Тэргүүний байгууллага”-аар шалгарсан Дархан сумын ИТХ-ын ажлын албаны үйл ажиллагаатай танилцаж, туршлага судаллаа.

## МЭДЭЭЛЭЛ

### АЛСЛАГДСАН ГЭР ХОРООЛОЛД СЭРЭМЖЛҮҮЛЭГ САМБАР БАЙРЛУУЛЛАА

Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар багийн алслагдсан гэр хороолол “Мангирт”-ын зам дагуу “Хурдаа тохируул” анхааруулга бүхий зургаан ширхэг сэрэмжлүүлэг самбарыг тус багаас сонгогдсон Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгч Г.Мөнхцэцэгийн дэмжлэгээр хийв.



Дархан сумын 15 дугаар багийн Засаг дарга Г.Отгонбаатар: “Манай багийн нутаг “Мангирт” хорооллын зам дагуу зам тээврийн осол гарах магадлал бүхий эргэлт, уулзваруудад сэрэмжлүүлэг самбарыг байршуулсан. Тээврийн хэрэгсэл жолоодогчид халтиргаатай замд хурд хэтрүүлснээс эрдэнэт хүний амь нас хохирч бэртэж гэмтэх, эд хөрөнгө сүйдэх явдлаас урьдчилан сэргийлсэн үр нөлөөтэй ажил боллоо.

### ҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХОРОО ХУРАЛДАВ

Дархан сумын ИТХурал 31 Төлөөлөгчидтэй. Төлөөлөгчид 5 салбар хороонд харъяалагдан үйл ажиллагаа явуулдаг. “Хүний хөгжил, нийгмийн бодлогын хороо” 2017.03.16-ны өдөр хуралдаж 2017 оны хоёрдугаар улиралд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд гишүүдээсээ санал авчээ.



Хүний хөгжил, нийгмийн бодлогын хороо хүүхэд залуучуудад бүх талаар сурч боловсрох, иргэдэд ажил хөдөлмөр эрхэлж өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн эмзэг бүлэг бүрт үзүүлэх халамжийн үйлчилгээг оновчтой болгоход чиглэгдсэн үйл ажиллагааг явуулахыг зорьж ажиллаж байна.

### ИТХ-ЫН ДЭРГЭДЭХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ХОРООНООС ШАЛГАЛТ ХИЙВ

Хууль эрх зүй, өргөдөл гомдлын хорооноос 2017.02.16 ны өдөр Дархан сумын хэмжээнд хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын арчлалт хамгаалалтын талаар үзлэг шалгалтыг хийв. Тэд ХХБ-аас 25 жилийнхээ ойгоор бүтээн босгож 2015 онд ашиглалтад өгсөн нийтийн тээврийн авто зогсоолыг сонгон авчээ.



Төсвийн хөрөнгийг зарахгүйгээр хотын бүтээн байгуулалтад аж ахуй нэгжүүдээс оруулсан үнэт хөрөнгө, сэтгэл зүрхээ зориулсан сайн жишээний нэг.. Сүүдрэвч, сандал бүхий нэг автобусны буудлыг 2.7 сая төгрөг буюу нийт 27 сая төгрөгөөр байгуулжээ. Гэвч дээрх 10 автобусны буудлаас өнөөдрийн байдлаар хоёрхон буудал хэвийн, бусад 8 буудлыг эвдэж сүйтгэжээ.



Шил нь хагархай, цахилгааны утас нь тасарсан, элдэв төрлийн зарлалаар дүүрч сарзайсан төмөр болсон дүр зураг иргэдийн нүдэнд дасал болох шиг. Бүтээн байгуулалтын ажлыг хөрөнгө зарлагдаж хийсэн ч цаашид эзэнтэй болгож арчлалт хамгаалалтыг сайжруулах шаардлагатай. Нөгөөтэйгүүр хотын иргэдийн ухамсар доройтсныг илтгэн харуулж байна. Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгчид цаашид орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бүтээн байгуулалтуудыг шалгаж холбогдох байгууллагуудад ажлын хэсгийн дүгнэлт гаргаж, өмчийг хариуцах эзэнтэй болгох талд анхаарч ажиллах болно.



## ИРГЭНИЙ ТАНХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

### “ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ-ИРГЭДИЙН АМЬДРАЛД” НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙВ

Дархан сумын ИТХ-ын дэргэдэх Иргэний танхим, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх сүлжээ ХК-тай хамтран 2017.02.17-ны өдөр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, Эрчим хүчний зохицуулах хорооноос гэр хорооллын иргэдийн цахилгааны шөнийн тарифыг 50 хувиар хөнгөлөх шийдвэр гаргасан. Төвийн бүсийн 13 аймаг хөнгөлөлт эдлэх ба эдгээрт Дархан-Уул аймаг багтсан байна.



Явуулын хэлэлцүүлэгт Дархан сумын ИТХ-ын дарга Ж.Балжинням, ДСЦТСүлжээ ХК-ийн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Батжаргал, Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК-ны Дархан хэрэглэгчдэд үйлчлэх төв, Дархан түгээх төв, Хэмжүүр тоолуур лабораторийн алба, Борлуулалтын бодлого зохицуулалтын хэлтэс, Техникийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтнүүд оролцлоо. Түүнчлэн МХГ-ын хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч Б.Оюунтуяа, Стандартчлал хэмжил зүйн хэлтсийн улсын байцаагчид оролцож иргэдийн асуултад хариулт өглөө. Дархан сумын 1-3 дугаар баг 3717 хэрэглэгчтэй. Үүнээс 1718 өрх ухаалаг тоолууртай бөгөөд шөнийн тариф 50 хувийн хөнгөлөлтөд хамрагдаж байгааг ДСЦТСүлжээ ХК-ийн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Батжаргал хэлэв. “Эрчим хүчний хэмнэлт-Иргэдийн амьдралд” явуулын хэлэлцүүлэгт Дархан сумын 1,2,3 дугаар багийн 80 орчим иргэд оролцож санал хүсэлтээ илэрхийлсэн байна. Иргэдийн зүгээс: Хэрэглэгч хангагч байгууллагын хоорондын харилцаа, Төлбөр тооцооны маргаан, Техник технологи нэвтрүүлэх үлдсэн айлуудад ухаалаг тоолуур суурилуулах зэрэг асуудлыг хөндөн ярих. Хэлэлцүүлгийн үеэр ДСЦТСүлжээ ХК-ийн хэмжүүр тоолуур лабораторийн алба тоолуурын баталгаажуулалт хийх, өр төлбөр шүүх, санал хүсэлт гомдол гаргасан 21 айлын асуудлыг газар дээр нь шийдвэрлэж ажиллав.


## МЭДЭЭЛЭЛ



Хэлэлцүүлгийн үеэр гарсан саналын дагуу ДСЦТС ХК-ийн шуурхай баг ажиллаж тоолуурын баталгаажуулалт хийж хэрэглэгчдэд зөвлөгөө мэдээлэл өгч цаасаар болон биечлэн 30 гаруй иргэний хүсэлт гомдлыг хүлээн авч барагдууллаа. Мөн хэлэлцүүлэгт оролцсон иргэдээс тавьсан хүсэлтийн дагуу гурван газарт долоон ширхэг шон босгож айлуудын унжиж тасарсан гэмтэлтэй цахилгааны утасыг шинээр үнэ төлбөргүй сольж өглөө



Эрчим Хүчний Зохицуулах Хорооны 2016 оны 10 сарын 28-ны өдрийн 159 тоот тогтоолоор мөн оны 11 сарын нэгнээс энэ сарын 31-ний өдрийг дуустал гэр хорооллын айл өрхөд борлуулах цахилгааны шөнийн хэрэглээний тарифыг 50 хувиар хөнгөлөхөөр тогтоосон. Үүний дагуу гэр хорооллын айл өрхийн шөнийн хэрэглээний 77,10 төгрөгийг 50 хувиар хөнгөлж 38,55 төгрөгөөр тооцож төлбөр нэхэмжилсэн тухай Дархан Сэлэнгийн Цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн Борлуулалтын бодлого зохицуулалтын хэлтсийн дарга С.Батбаатар ярив. “Дархан сумын хэмжээнд 3700 орчим айл ухаалаг тоолууртай учир 50 хувийн хөнгөлөлт эдлэлээ. Гэр хорооллын хэрэглэгчдийн шөнийн тарифт 173,3 сая төгрөг төлөхөөс 86,8 сая төгрөг төлж 86,5 сая төгрөгийг хэрэглэгчид төлөхгүйгээр хэмнэгдсэн байна.



## МЭДЭЭЛЭЛ

---

Иргэдийн санал шүүмжлэлийн мөрөөр Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК-иас хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээллийг Дархан сумын Иргэний танхимд ирүүлж, айлуудын оруулгын кабелийг шинээр солих, тоолуур төвлөрүүлсэн хайрцагт үзлэг шалгалт хийх, автомат ампер солих ажлыг үнэ төлбөргүй хийж гүйцэтгэсэн байна.



# МЭДЭЭЛЭЛ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

## ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА, САМБАРТАЙ БОЛЛОО

### ДАРХАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

#### МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт Дарханчуудынхаа амьдрал, ажил үйлст эрүүл энх, амжилт бүтээлийн дэвсгэр хүсэн ирвэл амжилтай.

Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгчид бид хуулар олондосон бичрэн эрхээ хэргэлжүүлж, иргэдийн эрх ашиг, орон нутгийн хөгжлийн төлөө ажилтай Хурал, Засаг даргатай бодлого үйл ажиллагаагаа уусгуулан ажилладаг байна.

Бид иргэдийнхээ бүтэцлэл санаачлага, идэвхтэй оролцооноо "туургуулан", орон нутгийн хөгжлийг түргэтгэх, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амжилтаар амьдрах нөхцөлийг сайжруулах төрлийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд сум, багийн удирдагчдаа чиглүүлэн мөнгөйлж ажиллана.

Иргэдээ төлөөлөн байгуулалтын хувьд сумын ИТХ-ын үүр хариуаа иргэн Таны өмнө цаг ямагт нээлттэй байх болно.

Та бид хамтдаа төрөлх Дархан хотоо хөгжүүлж чадна.

**ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН ДАРГА**  
**Ж.БАЛЖИННЯМ**

**ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧИД**

Ж.Балжинням, Н.Болор-Эрдэнэ, Э.Эрдэнбат, Б.Лхагвасурэн, Т.Чимгээ, Р.Уриангуу, Д.Жамбалдорж

1 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.ДАВАСАМБУУ</b> ☎ 99119021 ✉ davassambu@darkhan.gov.mn	2 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.БАДАМЦАН</b> ☎ 99022174 ✉ badamtsan@darkhan.gov.mn	3 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.ЛХАГВАСУРЭН</b> ☎ 99022174 ✉ lkhagsuren@darkhan.gov.mn	4 дугаар багийн Төлөөлөгч <b>Д.ТУГАА</b> ☎ 99022174 ✉ tugaa@darkhan.gov.mn	5 дугаар багийн Төлөөлөгч <b>Н.БОЛОР-ЭРДЭНЭ</b> ☎ 99022174 ✉ bolorerdene@darkhan.gov.mn	6 дугаар багийн Төлөөлөгч <b>Д.ЖАМБАЛДОРЖ</b> ☎ 99022174 ✉ jambaldorj@darkhan.gov.mn	7 дугаар багийн Төлөөлөгч <b>Х.УУЛАНБАЯР</b> ☎ 99022174 ✉ uulanyabayar@darkhan.gov.mn	8 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.ОЮУНЧИМЭГ</b> ☎ 99022174 ✉ oyunchimeg@darkhan.gov.mn
9 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.БАЛЖИННЯМ</b> ☎ 99022174 ✉ baljinyam@darkhan.gov.mn	10 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.ТӨГӨВШӨР</b> ☎ 99022174 ✉ togovshor@darkhan.gov.mn	11 дугаар багийн Төлөөлөгч <b>Я.БАТ-ОЧИР</b> ☎ 99022174 ✉ batochir@darkhan.gov.mn	12 дугаар багийн Төлөөлөгч <b>Х.УУЛГАА</b> ☎ 99022174 ✉ uulgaaga@darkhan.gov.mn	13 дугаар багийн Төлөөлөгч <b>З.ЭРЭНЭХБАТ</b> ☎ 99022174 ✉ erenekhbat@darkhan.gov.mn	14 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.БААСАЖАВ</b> ☎ 99022174 ✉ baasajav@darkhan.gov.mn	15 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.УУЛАНБАЯР</b> ☎ 99022174 ✉ uulanyabayar@darkhan.gov.mn	16 дугаар багийн Төлөөлөгч <b>М.БАТБАЯР</b> ☎ 99022174 ✉ batbayar@darkhan.gov.mn
17 дугаар багийн Төлөөлөгч <b>С.МЭНХУЛ</b> ☎ 99022174 ✉ menkhul@darkhan.gov.mn	18 дугаар багийн Төлөөлөгч <b>Д.ЖАМБАЛДОРЖ</b> ☎ 99022174 ✉ jambaldorj@darkhan.gov.mn	19 дугаар багийн Төлөөлөгч <b>Г.ГАЛТУГАА</b> ☎ 99022174 ✉ galtagaaga@darkhan.gov.mn	20 дугаар багийн Төлөөлөгч <b>С.СОРЖОНБОЛОР</b> ☎ 99022174 ✉ sorjombolor@darkhan.gov.mn	21 дугаар багийн Төлөөлөгч <b>У.ЧИНМЭГ</b> ☎ 99022174 ✉ chinmeg@darkhan.gov.mn	22 дугаар багийн Төлөөлөгч <b>Г.ГАЛТУГАА</b> ☎ 99022174 ✉ galtagaaga@darkhan.gov.mn	23 дугаар багийн Төлөөлөгч <b>З.ЭРЭНЭХБАТ</b> ☎ 99022174 ✉ erenekhbat@darkhan.gov.mn	24 дугаар багийн Төлөөлөгч <b>Ч.БАТТУГАА</b> ☎ 99022174 ✉ battagaaga@darkhan.gov.mn

Сумын хөгжлийн бодлогын хороо  
Хүний хөгжил, нийгмийн бодлогын хороо  
Үйлдвэрлэл худалдаа, үйлчилгээ, байгаль орчин, хот байгуулалтын бодлогын хороо  
Төсөл хөтөлбөр, гадаад харилцааны бодлогын хороо  
Хууль эрх зүй, өргөдөл гомдлын хороо  
ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН АЖЛЫН АЛБА

**ДАРХАН СУМЫН БАГУУДЫН ИНХ-ЫН ДАРГА НАР**

1 дугаар баг Ц.Лхагвасурэн, 2 дугаар баг Ц.Мөнхбаатар, 3 дугаар баг Б.Туугалы, 4 дугаар баг Д.Балзор, 5 дугаар баг Б.Валццэг, 6 дугаар баг П.Ганбат, 7 дугаар баг Ж.Өнэй-Оюун, 8 дугаар баг Б.Болорбаатар, 9 дугаар баг Г.Ватбаяр, 10 дугаар баг Т.Мөнхбат, 11 дугаар баг Л.Урианчимэг, 12 дугаар баг Н.Сундаа, 13 дугаар баг Д.Цэрэнцаваа, 14 дугаар баг Д.Эрдэнэ-Очир, 15 дугаар баг У.Нарангарал, 16 дугаар баг Б.Ганзориг, Өргөө баг С.Сүхбаатар, Малчин баг О.Адыяа.

[www.darkhan.darkhan-uhl.khural.mn](http://www.darkhan.darkhan-uhl.khural.mn)

[www.darkhansum\\_lth@yahoo.com](mailto:www.darkhansum_lth@yahoo.com)

#### ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧИД, БОДЛОГЫН ХОРООД

**ТЭРГҮҮЛЭГЧИД**  
Ж.Балжинням, Н.Болор-Эрдэнэ, Э.Эрдэнбат, Б.Лхагвасурэн, Т.Чимгээ, Р.Уриангуу, Д.Жамбалдорж

**СУМЫН ХӨГЖИЛНИЙ БОДЛОГЫН ХОРОО**  
Дарга Я.Бат-Очир, Гишүүд Ж.Балжинням, Б.Бадамцан, Н.Болор-Эрдэнэ, Б.Баасажав, В.Бат-Эрдэнэ, Д.Жамбалдорж, Ч.Баттуугаа, Т.Чимгээ

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХОРОО**  
Дарга С.Мөнхул, Гишүүд Б.Лхагвасурэн, Б.Оюунчимэг, Д.Жамбалдорж, Х.Туугаа, Г.Балчамаа, Г.Гантуугаа

**ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ, БАЙГАЛЬ ОРЧИН, ХОТ БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГЫН ХОРОО**  
Дарга Б.Даваасамбуу, Гишүүд Б.Балжынням, Б.Оюунчимэг, М.Батбаяр, Э.Цэрэнцаваа, Д.Туугаа, Э.Дамбалорсамбуу

**ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫН ХОРОО**  
Дарга П.Имбаяр, Гишүүд Б.Төгөвшөр, Б.Ууланбаяр, А.Соржонболор, Г.Мөнхцэцэг

**ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ХОРОО**  
Дарга Р.Уриангуу, Гишүүд Б.Нямбаатар, Б.Ганзориг

**ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН АЖЛЫН АЛБА**

Ж.Балжинням, Б.Болорбаатар, В.Пүрэвзориг, Г.Мөнх-гарал, О.Бадамдорж, П.Норовсүрэн

#### ТА БИД ХАМТДАА ТӨРӨЛХ ДАРХАН ХОТОО ХӨГЖҮҮЛЖ ЧАДНА

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ**

Иргэн төлөө "Иргэдийн төлөөлөгчид" - зөвхөн эзэн нь бид, зүүнүүлж иргэний ардчилсан нийгэм байгуулах их үйлст хамтран ажиллахыг урьж байна.

**ИРГЭДЭЭ СОНХОХ НЭЭЛТТЭЙ УТАС**  
7637-3062  
9476-6062

Монгол улс, Дархан-Уул аймаг, Дархан сум, Өргөө баг, Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчид, ЗДТГ-ын байр

[www.darkhan.darkhan-uhl.khural.mn](http://www.darkhan.darkhan-uhl.khural.mn)  
[www.darkhansum\\_lth@yahoo.com](mailto:www.darkhansum_lth@yahoo.com)  
darkhansum\_lth



# МЭДЭЭЛЭЛ

## Мэндчилгээ




Эрхэм хүндэт Дарханчуудынхаа амьдрал, ажил үйлст эрүүл энх, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөж мэндчилье.

Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгчид бид хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлж, иргэдийн эрх ашиг, орон нутгийн хөгжлийн төлөө аймгийн Хурал, Засаг даргатай бодлого үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаж байна.

Бид иргэдийнхээ бүтэцлч санаачилга, идэвхтэй оролцоонд тулгуурлан, орон нутгийн хөгжлийг түргэтгэх, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулах, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд сум, багийн удирдлагуудаа чиглүүлэн манлайлж ажиллана.

Иргэдээ төлөөлсөн байгууллагын хувьд сумын ИТХ-ын үүд хаалга иргэн Таны өмнө цаг ямагт нээлттэй байх болно.

Та бид хамтдаа төрөлх Дархан хотоо хөгжүүлж чадна.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН  
ИТХ-ЫН ДАРГА  Ж.БАЛЖИННЯМ

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД

 1 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.ДАВААСМБУУ</b> ☎ 99115967 ✉ Davasambuu@yahoo.com	 2 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.БАДАМХАНД</b> ☎ 99032718 ✉ ms.badamkhand@gmail.com	 2 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.ЛХАВАСҮРЭН</b> ☎ 99032718 ✉ lkhavassuren@yahoo.com	 3 дугаар багийн Төлөөлөгч <b>Д.ТУЛА</b> ☎ 99399361 ✉ tula_191@yahoo.com	 3 дугаар багийн Төлөөлөгч <b>Н.БОЛОР-ЭРДЭНЭ</b> ☎ 99378922 ✉ bolor_erdene@yahoo.com	 4 дугаар багийн Төлөөлөгч <b>Д.ЖАМБАЛДОРЖ</b> ☎ 95378215 ✉ jambaldorj@gmail.com	 5 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.ОЮУНЧИМИГ</b> ☎ 99134116 ✉ oyunchimig@yahoo.com	 5 дугаар багийн Төлөөлөгч <b>Ж.БАЛЖИННЯМ</b> ☎ 99029230 ✉ szergun@yahoo.com
 6 дугаар багийн Төлөөлөгч <b>Р.УРАНГА</b> ☎ 99057595 ✉ uranga20@gmail.com	 6 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.БАЯСГАЛАН</b> ☎ 99018521 ✉ bayasgalan@yahoo.com	 7 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.ТҮГҮЛДОР</b> ☎ 99394481 ✉ tuguldor@yahoo.com	 7 дугаар багийн Төлөөлөгч <b>Я.БАТ-ОЧИР</b> ☎ 99040017 ✉ y_batochir@yahoo.com	 7 дугаар багийн Төлөөлөгч <b>Х.ТҮГЛАА</b> ☎ 99081995 ✉ x_tuglaa@gmail.com	 8 дугаар багийн Төлөөлөгч <b>З.ЭРДЭНБАТ</b> ☎ 99378038 ✉ zerdenebat@gmail.com	 8 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.БААСАНЖАВ</b> ☎ 99162206 ✉ baasanjav@yahoo.com	 8 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.УУТАНБАЙАР</b> ☎ 99063254 ✉ urhanbayar20@gmail.com
 9 дугаар багийн Төлөөлөгч <b>М.БАЛТАЙАР</b> ☎ 99040026 ✉ mbaltayar20@yahoo.com	 9 дугаар багийн Төлөөлөгч <b>В.БАТ-ЭРДЭНЭ</b> ☎ 99075132 ✉ vbaterdene@gmail.com	 10 дугаар багийн Төлөөлөгч <b>Д.ЖАРГАЛСҮРЭН</b> ☎ 99084270 ✉ djargalsuren@yahoo.com	 10 дугаар багийн Төлөөлөгч <b>П.ХАЙАР</b> ☎ 99032089 ✉ p_khayr@gmail.com	 11 дугаар багийн Төлөөлөгч <b>С.МҮНКЗҮЛ</b> ☎ 99370863 ✉ smunkzul@yahoo.com	 12 дугаар багийн Төлөөлөгч <b>А.СОРОНЗОНБОЛД</b> ☎ 88011003 ✉ soronzonbold@gmail.com	 13 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.НЯМБАЙАР</b> ☎ 95378034 ✉ nyambayr_3@yahoo.com	 14 дугаар багийн Төлөөлөгч <b>З.ДОРЖЗОЛМАА</b> ☎ 99053307 ✉ zdorjzoolmaa@gmail.com
 15 дугаар багийн Төлөөлөгч <b>Ч.БАТТУГА</b> ☎ 99087756 ✉ chbatuga@gmail.com	 15 дугаар багийн Төлөөлөгч <b>Г.АЛТИМИГ</b> ☎ 99129673 ✉ Chimg47@gmail.com	 15 дугаар багийн Төлөөлөгч <b>Г.МҮНКХШАРВАЙ</b> ☎ 94090760 ✉ gmsh1511@yahoo.com	 16 дугаар багийн Төлөөлөгч <b>Б.ГАНЗОРИГ</b> ☎ 99014463 ✉ gan_batol@yahoo.com	 16 дугаар багийн Төлөөлөгч <b>Т.ЧИМГЭЭ</b> ☎ 99377178 ✉ chimgaee5@gmail.com	 Өргөө багийн Төлөөлөгч <b>Г.ГАНУУГА</b> ☎ 88088400 ✉ ganee888@yahoo.com	 Малчин багийн Төлөөлөгч <b>З.ДАМЗОРИГСАМБУУ</b> ☎ 99372220 ✉ zdamzorig20@gmail.com	

Дархан сумын ИТХ-ын мэдээ мэдээллийг орон нутгийн 4 телевиз, үндэсний хэмжээний Монцаме сайт, төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд байнгын мэдээлж ирлээ.




## МЭДЭЭЛЭЛ

### ДАРХАН СУМЫН ГХУСАЗЗӨВЛӨЛ

Дархан сумын ГХУСАЗЗ-ийн хуралдаан 3 удаа хуралдаж, дараах асуудлыг авч хэлэлцэв. Үүнд:



- ✓ Сумын хэмжээнд 2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулсан ажлын тайлан, мэдээлэл
- ✓ Дархан сумын ГХУСАЗЗ-ийн 2017 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлах тухай
- ✓ Зөвлөлийн ажиллах журмыг батлах тухай
- ✓ Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, цаашид авах арга хэмжээ
- ✓ Насанд хүрээгүй этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг шийдвэрлэсэн байдал
- ✓ Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал чиглэлээр 2016 оны ажлын тайлан
- ✓ Дархан сумын 1, 2, 3, Өргөө багуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ
- ✓ Онцгой байдлын газраас цаг үеийн нөхцөл байдал / шар усны үер, гал түймрээс урьдчилан сэргийлэх/ цаашид авах арга хэмжээний талаарх мэдээлэл
- ✓ Дархан сумын хэмжээнд “Хамтарсан баг” -ийн 2017 оны эхний улиралд хийсэн ажлын тайлан мэдээлэл зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.



Зөвлөлийн хуралдаанаар тайлан мэдээллийг сонсоод, Гишүүдээс гаргасан саналуудыг 2017 оны ажилд тусган хэрэгжүүлэх талаар Дархан сумын Засаг дарга Б.Азжаргалд “Зөвлөмж” хүргүүлэв.


“Амгалан Дархан” хөтөлбөрийн хүрээнд :

- ✓ 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт Төмөр замын өртөөний орчимд Цагдаагийн хэсэг байгуулах
- ✓ 18 багийн цагдаагийн хэсгийн байцаагч нарт шаардлагатай байгаа техник, тоног төхөөрөмжийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх.



## МЭДЭЭЛЭЛ

Зөвлөл сар бүр хуралдаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар төлөвлөгөөнд тусгагдсан тухайн байгууллагуудын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар хамтран ярилцаж, холбогдох үүрэг чиглэлийг өгч ажиллаж байна.



Дархан сумын ГХУСАЗЗ-ийн 2017 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан “Хамтарсан баг-Иргэдийн амьдралд” аян зохион байгуулж, 2017 оны 2 дугаар улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

# МЭДЭЭЛЭЛ

БАТЛАВ.

ИТХ-ЫН АЖЛЫН  
АЛБАНЫ ДАРГА

Б.БОЛДБААТАР

## ДАРХАН СУМЫН ИТХ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛЭГЧИД, АЖЛЫН АЛБАНЫ 2017 ОНЫ 2 УЛИРЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2017.04.01

Дархан

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа /сараар/			Хариуцах эзэн
		4	5	6	
1.	Дархан сумын ИТХ-ын 2017-2020 онд баримтлах үйл ажиллагааны үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах				Тэргүүлэгчид, ажлын алба
2.	Тэргүүлэгчдийн хуралдаанаар цаг үеийн болон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, хэрэгжилтэнд хяналт тавих				Тэргүүлэгчид, ажлын алба
3.	Сумын ИТХ-ын Хороодыг шуурхай удирдлагаар хангаж, үйл ажиллагааг идэвхжүүлэх, <b>тогтмолжуулах</b>				Тэргүүлэгчид, ажлын алба
4.	2017 оны орон нутгийн төсөвт тодотгол хийх тухай				ИТХ, ажлын алба
5.	Засаг даргын "Үйл ажиллагааны хөтөлбөр" /2017-2020/ оны хэрэгжилтийг хангуулах				Сумын хөгжлийн хороо
6.	Монгол улсын хэмжээнд шинэлэг арга хэлбэрүүд нэвтрүүлсэн нийслэлийн дүүрэг, аймаг, сумдын ИТХ-ын үйл ажиллагаатай танилцах, туршлага солилцох				Тэргүүлэгчид, ажлын алба
7.	Орон нутгийн ИТХ-ын Төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулах, туршлага солилцох				Багийн ИНХ-ын дарга нар
8.	Багуудын ИНХ-ын чадамжийг дээшлүүлэх сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах				Багийн ИНХ-ын дарга нар
9.	Багийн ИНХ-ын дарга нарыг ИТХ-ын хуралдаанд таслах эрхгүй, санал хэлэх эрхтэйгээр оролцуулах				ИТХ-ын ажлын алба, ЗДТГ
10.	Сум хөгжүүлэх сангийн журмын хэрэгжилт, зээлийн чанар үр дүнд шинжилгээ хийх, хяналтын үйл ажиллагааг сайжруулах				ИТХ-ын хороод
11.	Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтанд хяналт шалгалт хийх				ИТХ-ын хороод
12.	Нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд хяналт тавих				ИТХ-ын хороод
13.	Гэр хорооллын иргэдийн тулгамдсан асуудлууд				Иргэний танхим
14.	Малчин багийн иргэдэд тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг				Иргэний танхим
15.					Ажлын алба

## МЭДЭЭЛЭЛ

	Засаг даргын тайланг багийн иргэдээр хэлэлцүүлэх,				ЗДТГазар
16.	УИХ-аас шинээр батлагдсан болон өөрчлөгдсөн хууль тогтоомжоор иргэдэд мэдээ, мэдээлэл өгөх				Аймаг сумын иргэний танхим
17.	Сумын ИТХ, иргэдэд үйлчлэх төв болон цахим хэлбэрээр ирсэн гомдол саналын мөрөөр шийдвэрлэж ажиллах				Хууль эрх зүй өргөдөл гомдлын хороо, Хэвлэл мэдээллийн ажилтан
18.	Иргэдийн өмнө тулгамдаж байгаа асуудлаар холбогдох мэргэжилийн байгууллагуудтай хамтран ажиллах				Иргэний танхим Ажлын алба
19.	<i>Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн</i> бэлтгэл ажлыг хангаж, хуулийн хүрээнд батлагдсан цагалбарын дагуу зохион байгуулах, хяналт тавих				Тэргүүлэгчид, ажлын алба
20.	Шилэн дансны хуулийн хэрэгжилт, санхүүгийн ил тод байдлыг хангах, санхүүгийн баримт, холбогдох бичиг баримтын стандартыг сайжруулах				Ажлын алба
21.	Сумын ИТХ-ын хуралдааны бэлтгэлийг хангах				Ажлын алба
22.	Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны бэлтгэлийг хангах				Ажлын алба, Хууль эрх зүй өргөдөл гомдлын хороо
23.	Улирал бүр төлөвлөгөө гарган, биелэлтийг хангах				Ажлын алба, сумын ЗДТГ
24.	ИТХ-аас гарах тогтоол, бусад баримт бичгийн стандартыг сайжруулна				Тэргүүлэгчид, ажлын алба
25.	ИТХ-аас гарсан тогтоол шийдвэрийн биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж тайлагнах				Ажлын алба
26.	Сумын ИТХ-ын ажлын албанд болон багуудын ИНХ-аас гарсан гомдол саналуудыг шийдвэрлүүлэн, хариуг иргэн бүрт хүргэх				Ажлын алба
27.	2017 онд “Алдарт эх”-ийн 1, 2 дугаар одонгоор шагнагдах ээжүүдийн материалыг хүлээн авч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд уламжлах				Ажлын алба
28.	<a href="http://www.khural.mn">www.khural.mn</a> . facebook, хаягуудын хөтлөлтийг сайжруулах, мэдээлэл оруулах, цахим сан бий болгох				Ажлын алба
29.	Төвийн болон орон нутгийн телевизүүдэд Сумын ИТХ, Төлөөлөгчдийн болон багийн ИНХ-ын үйл ажиллагааг сурталчлах, мэдээ, мэдээлэл өгөх				Ажлын алба
30.	Сумын ИТХ, Төлөөлөгчдийн болон багийн ИНХ-ын үйл ажиллагааг сонин, сэтгүүл,				Хэвлэл



## МЭДЭЭЛЭЛ

	сайтуудад мэдээлэл байршуулах, төвийн хэвлэлд мэдээлэл өгөх				мэдээлэл
31.	Багийн ИНХ-ын дарга, Засаг дарга нарын хамтарсан зөвлөгөөн зохион байгуулах				Хурлын ажлын алба
32.	Нутгийн Удирдлагын холбооны сэтгүүлд мэдээлэл тавх				Хурлын ажлын алба
33.	Хамтарсан багийн үйл ажиллагааг чадваржуулах сургалт зохион байгуулах				Хурлын ажлын алба
34.	Багуудын төвүүдэд байрлах санал хүсэлтийн хайрцагийн үйл ажиллагаатай танилцах				Хороод ажлын алба
35.	Төлөөлөгчид, багуудын ИНХ-ын дарга нарын хамтарсан зөвлөгөөн зохион байгуулах - СӨБ, ЕБС-уудын үйл ажиллагааны талаар - Эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааны талаар				Хурлын ажлын алба БСУГ ЭМГ
36.	ГХУСА33-ийн хуралдаанаар - Дархан сумын 4, 5 дугаар багийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ - ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ				ГХУСА33
37.	ЕБС-уудын дунд “Цахим орчноос хүүхдээ хамгаалъя” сэдэвт санал асуулга зохион байгуулах				ГХУСА33 Ажлын алба ГБХЗХГ
38.	2017 оны төсвийн төсөл, 2018-2020 оны төсвийн төсөөлөл бэлтгэх				
39.	Сар бүрийн санхүүгийн гүйцэтгэлийн мэдээг гаргаж төрийн санд хүргүүлэх				Б.Пүрэвсүрэн
40.	Хагас жилийн санхүүгийн баланс гаргах, бэлтгэл хангах				Б.Пүрэвсүрэн
41.	2017 оны орон нутгийн төсөвт тодотгол хийх тухай, тодотголтой холбоотой төсвийн хуваарийг шинэчлэн гаргах				Б.Пүрэвсүрэн
42.	Төсвийн төслийн талаар санал авах				Б.Пүрэвсүрэн

ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН  
АЖЛЫН АЛБА